

СТАТИСТИКИЙН ТАНИЛЦУУЛГА



**Дүүргийн эдийн
засаг, нийгмийн
байдал**

**2016 он
9-р сар**

АГУУЛГА

Хуудасны
тоо

1. ДҮҮРГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	3
2. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	4
3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ	7
4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	8
5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	9
6. НИЙГМИЙН ДААТГАЛ	11
7. НИЙГМИЙН ХАЛАМЖ	11
8. УЛААН ЗАГАЛМАЙ	12
9. АЖ АХУЙН НЭГЖ	12
10. АЖ ҮЙЛДВЭР	13
11. ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	14
12. ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ	15
13. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	15
14. ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ	16
15. ЗАХИРГААНЫ МЭДЭЭ	16
16. ГЭМТ ХЭРЭГ	17
17. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ЗӨРЧИЛ	18
18. ХҮҮХЭД, ГЭР БҮЛ ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ	18
19. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ	19
20. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ ГАМШИГ	20
21. ЦЭРГИЙН ШТАБ	21
22. АХМАДЫН ХОРОО	21

Хүснэгт 1. Дүүргийн үндсэн үзүүлэлт. 2016 оны 9 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015 он	2016 он
Суурин хүн ам /жилийн эцэст/	Хүн	159514	154819
Төрөлт	Тоо	3474	3174
Шинээр төрсөн хүүхэд	Тоо	3141	2826
Нас баралт	Тоо	617	525
Халдварт өвчин	Тоо	3780	3638
Ажилгүйчүүд	Хүн	2794	2063
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	1756	1857
Дүүргийн төсвийн орлого	Сая төгрөг	43204.7	48420.1
Дүүргийн төсвийн зарлага	Сая төгрөг	39651.6	49877.3
Валютын ханш	1US\$=₮	1997	2287




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2016 оны 9-р сарын хэрэглээний үнийн индекс 2015 оны мөн үетэй харьцуулахад 0.7 хувиар, өмнөх сартай харьцуулахад 0.9 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 2. Хэрэглээний үнийн индекс

Бараа үйлчилгээний бүлэг	Жин	<u>2016.08</u> <u>2015.08</u>	<u>2016.08</u> <u>2016.07</u>
Ерөнхий индекс	100,1	99.3	99.1
Хүнсний бараа, ундаа, ус	103.1	96.6	96.4
Согтууруулах ундаа, тамхи	104.4	104.4	101.3
Хувцас, бөс бараа	98.5	99.4	101.1
Орон сууц, ус, түлш, цахилгаан	93.4	98.4	100.3
Гэр ахуйн тавилга, бараа	100.6	101.4	99.8
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	106.9	108.1	100.3
Тээвэр	98.1	98.5	100.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.7	100.7	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	98.2	98.9	100.0
Боловсролын үйлчилгээ	102.6	102.6	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	100.0	100.9	100.0
Бусад бараа, үйлчилгээ	99.9	100.3	100.1

Зураг 1. Хэрэглээний үнийн өсөлт, сараар



Хэрэглээний үнийн индекс 2016 оны 9-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 3.1 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 4.4 хувиар, гэр ахуйн бараа, тавилга 0.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 6.9 хувь, Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ 0.7, боловсролын үйлчилгээ 2.6 хувь, Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 1.4 хувь, Бусад бараа, үйлчилгээ 0.3 хувь тус тус нөлөөлжээ.


Хүснэгт 3. Бараа бүтээгдэхүүний дундаж үнэ, төгрөг / 9 сар/

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2012	2013	2014	2015	2016
Алтан тариа 1-р зэрэг	кг	700	750	1000	1000	1065
Атар талх	ш	650	780	1050	1067	1160
Цагаан будаа	кг	1600	1900	2200	2200	2575
Шар будаа	кг	1400	1400	1700	1700	1730
Хонины мах	кг	7000	7000	6000	6200	4800
Үхрийн мах	кг	7800	8400	7800	7467	5905
Адууны мах	Кг	5800	6000	4800	5500	4405
Тахианы гуя	кг	4000	5500	6500	6667	6300
Сүү задгай	л	900	1000	1100	1050	1250
Хорхой ааруул	кг	8000	7000	10000	9000	9300
Өндөг	ш	250	280	285	300	270
Ургамлын тос	л	2600	2900	3000	3267	3355
Алим, кг	кг	3200	3000	3500	3667	4170
Банан, шар	кг	3000	4000	5000	5000	5000
Төмс	кг	1200	600	1200	1200	845
Лууван	кг	1500	800	1800	1600	930
Сонгино	кг	1000	1200	1100	1000	1280
Элсэн чихэр	кг	1600	1500	1650	1600	2315
Цэвэр усны үнэ тоолуургүй 1 хүний	хүн	3201.6	3201.6	4705.8	4705.8	4705.8
Эдийн саван ОК	ш	450	450	533	600	650
Угаалгын нунтаг "ОМО"	ш	580	650	800	833	860
Аяга, таваг угаагч шингэн, "Fairy"	ш	2750	3000	3600	4067	4100


Зураг 2. Алтан тариа дээд гурил, атар талхны үнэ, 2012-2016 он



Зураг 3. Нэг кг хонь, үхрийн махны дундаж үнэ, 2011-2016 он



Зураг 4. Нэг кг лууван, төмсний дундаж үнэ, 2011-2016 он



Зураг 5. Нэг кг сонгино, байцааны дундаж үнэ, 2011-2016 он



Зураг 6. Шатахууны үнэ, 2011-2016 он



ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого: Орон нутгийн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 2016 оны 9-р сарын байдлаар 48420.1 сая төгрөг, нийт зарлага цэвэр зээлийн дүн 49877.3 сая төгрөг болж, орон нутгийн төсвийн нийт тэнцэл 1457.1 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан байна.

Орон нутгийн нийт төсвийн төлөвлөгөөний биелэлтийг нэр тус бүрээр нь доорх хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 4. Төсвийн урсгал орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Биелэлт
Нийт орлогын дүн	44091309.9	48420121.1	4328811.2	9.8
Урсгал орлого	19532081.5	24246090.7	4714009.2	24.1
1. Татварын орлого	19144902.1	23451989.9	4307087.8	22.5
Орлогын албан татвар	9734284.2	10028467.1	294182.9	3.0
Өмчийн татвар	49900.0	21713.0	-28187.0	56.5
Бусад татвар	9360717.9	13401809.8	4041091.9	43.2
2.Татварын бус орлого	387179.4	794100.8	406921.4	105.1
Тусламжийн орлого	24559228.4	24174030.4	-385198.0	1.6

Төсвийн төлөвлөгөөний биелэлт өмчийн татвар, тусламжийн орлогоос бусад нэр төрөл дээр төлөвлөснөөс давж бүрдсэн байна.

Төсвийн зарлага: Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 2016 оны 9-р сарын байдлаар 49877.3 сая төгрөг болж төлөвлөсөн хэмжээнээс 1521.6 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар төсвийн зардлыг хэмнэсэн байна.

Зураг 7. Төсвийн зардал



Төсвийн нийт зарлагын 29.3 хувийг цалин хөлс, 3.3 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 50.8 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 5.0 хувийг татаас, 2.3 хувийг урсгал шилжүүлэг, 9.3 хувийг хөрөнгө оруулалтын зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 5. Төсвийн зарлага


Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Биелэлт
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	51398910.1	49877273.5	-1521636.6	3.0
А. Урсгал зардлын дүн	44848628.7	45213060.8	364432.1	0.8
1.Бараа үйлчилгээний зардал	34333594.4	41572876.3	7239281.9	21.1
1.1 Цалин хөлс	14955573.2	14597017.2	-358556.0	2.4
1.2 НДШ хураамж	1677393.7	1625327.6	-52066.1	3.1
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал	17700627.5	25350531.5	7649904.0	43.2
2.Зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0	-
3.Татаас ба урсгал шилжүүлэг	10515034.3	3640184.5	-6874849.8	65.4
3.1 Татаас	6998755.7	2496984.5	-4501771.2	64.3
3.2 Урсгал шилжүүлэг	3521278.6	1143200.0	-2378078.6	67.5
Б. Хөрөнгийн зардал	6550281.4	4664212.7	-1886068.7	28.8
1. Хөрөнгө оруулалт	6550281.4	4664212.7	-1886068.7	28.8



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн хэлтсийн 2016 оны 9-р сарын мэдээгээр ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй 2063 иргэн бүртгүүлсэн байна. Нийт ажил хайж байгаа эмэгтэйчүүд 1232 буюу 59.7 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 15 буюу 0.7 хувь байна. Насны бүлгээр авч үзвэл нийт ажил хайж байгаа иргэдийн 233 буюу 11.3 хувь нь 15-24 насны, 941 буюу 45.6 хувь нь 25-34 насны, 483 буюу 23.4 хувь нь 35-44 насны, 310 буюу 15.0 хувь нь 45-54 насны, 96 буюу 4.7 хувь нь 55 дээш насны хүмүүс байна.

Зураг 8. Ажил идэвхитэй хайж байгаа иргэдийн тоо боловсролын түвшингээр



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн мэдээгээр 2016 оны 9дүгээр сарын байдлаар дүүргийн хэмжээнд 3174 эх амаржиж, 3197 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс амаржсан эхийн тоо 300 буюу 8.6

хувь, амьд төрсөн хүүхэд 310 буюу 8.8 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 6. Эмнэлгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд

Үзүүлэлт		2015.09	2016.09	Зөрүү	Хувь
Нийт үзлэг		545489	575029	29540	5.4
Үүнээс:	Урьдчилан сэргийлэх	215191	219264	4073	1.9
	Амбулаторид	156312	170837	14525	9.3
	Диспансерийн хяналт	68404	71623	3219	4.7
	Гэрийн үзлэг	102215	110013	7798	7.6
	Гэрийн дуудлагын үзлэг	3367	3292	-75	2.2
Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг		173653	198551	24898	14.3
Өрхийн эмчийн үзлэг		371836	376478	4642	1.2
Бүртгэгдсэн өвчлөл		25356	38026	12670	49.9
Үүнээс:	Шинэ	16198	24832	8634	53.3
	Хуучин	9158	13194	4036	44.1
Бүртгэгдсэн хорт хавдар		23	56	33	143.5
Осол гэмтэл		287	377	90	31.3
Хэвтсэн өвчтөн		7045	7487	442	6.3
Эмнэлгийн нас баралт		22	35	13	59.1
Хоног болоогүй нас баралт		10	7	-3	30.0
Эмчлэгдсэн өвчтөн		6852	7455	603	8.8
Түргэн тусламжийн дуудлага		2776	2765	-11	0.4

2016 он гарсаар 525 хүн нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс 92 хүнээр буюу 14.9 хувиар буурсан байна. Нийт нас баралтын дотор нялхсын эндэгдэл 39 буюу 7.4 хувь, 1-5 насны хүүхдийн эндэгдэл он гарсаар 5бүртгэгдсэн байна. Нялхсын эндэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 5.4 хувиар өссөн байна. 2016 оны 9 сарын байдлаар 575.0 мян.хүн үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 29.5 мян.хүн буюу 5.4 хувиар өсөж, харин эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний хүний тоо 7487 болж өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 9. Нийт үзлэг, төрлөөр



Хүснэгт 7. Халдварт өвчин

Үзүүлэлт	2015.09	2016.09	Зөрүү	Хувь	
Халдварт өвчин	3780	3638	-142	3.7	
Үүнээс:	Гепатит	41	18	-23	56.1
	Цусан суулга	201	230	29	14.4
	Сальмоннез	12	12	0.0	-
	Хоолны хордлого	16	76	60	3.7 дахин
	Менингит	1	0	-1	100.0
	Салхин цэцэг	224	191	-33	14.7
	Гахайн хавдар	3	17	14	4.6 дахин
	Улаан эсэргэнэ	25	89	64	2.5 дахин
	Ёлом	5	8	3	60.0
	Улаан бурхан	2101	1758	-373	16.3
	Улаанууд	5	0	-5	100.0
	Бруцеллёз	2	1	-1	50.0
	Гар, хөл, ам	103	371	268	2.6 дахин
	Тэмбүү	437	356	-81	18.5
	Заг хүйтэн	150	118	-32	21.3
	Трихомониаз	78	83	5	6.4
	Мөөгөнцөр	86	27	-59	68.8
	Сүрьеэ	274	259	-15	5.5
Бусад	16	22	6	37.5	

Дүүргийн хэмжээнд 2016оны 9 сарын байдлаар бүртгэгдсэн халдварт бус өвчлөл 38.0 мянга болж өнгөрсөн оны мөн үеэс 50.0 хувиар өссөн байна. Халдварт өвчин 3638 бүртгэгдсэн нь өмнөх оноос 3.7 хувиар буурсан нь улаан бурхан өвчний бууралттай холбоотой байна. Бэлгийн замын халдварт өвчин нийт халдварт өвчний 16.0 хувийг эзэлж байна. БЗХӨ өнгөрсөн оны мөн үеэс 22.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



НИЙГМИЙН ДААТГАЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны 9-р сард төсвийн 215 байгууллагын 21764 албан хаагчид, хувийн хэвшлийн 3703 аж ахуйн нэгжийн 61686 албан хаагчид, сайн дурын 11752 иргэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна. Эрүүл мэндийн даатгалд 40747 иргэн хамрагдсан. Үүнээс төр эрүүл мэндийн даатгалыг хариуцсан даатгуулагч 26135 байна.

Хүснэгт 8. Тэтгэвэр олголт

	Хүний тоо	Олгосон тэтгэмж	
		Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
Өндөр настан	15411	47349.2	46404.0
Тахир дутуу	3086	6862.9	6551.7
Тэжээгчээ алдсан	1009	1951.6	2206.4
Дүн	19506	56193.7	55162.1



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны 9-р сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 14.2 хувийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжинд, 2.7 хувийг хүнс тэжээл хөтөлбөрийн дансны санхүүжилтын орлогод тус тус хуваарилсан байна.

Хүснэгт 9. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, сая.төг

Үзүүлэлт	Үнийн дүн
Нийгмийн халамжийн сангийн орлого	10303.1
1. Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн төсвийн санхүүжилт	3027.8
а) Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	1467.5
б) Алдарт эхийн одонгийн тусламж	1050.0
с) Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	205.0
д) ОНОТХҮ үйлчилгээний санхүүжилтын орлого	22.5
е) Хүнстэжээлхөтөлбөрийн дансны санхүүжилтын орлого	282.8
2. Нийгмийн халамжийн сан	7260.2
а) Төсвийн санхүүжилтын орлого	7260.0
б) Бусад орлого	0.2
3. Хүүгийн орлого	15.1
Зарлагын нийт дүн	9233.9
1. Нийгмийн халамжийн сан	6657.5

2. Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	1478.7
3. Алдарт эхийн одонгийн тусламж	1075.2
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	-
5. Хүнс тэжээлийн хөтөлбөр	-
6. ОНОТХ. үйлчилгээ	22.5

Нийгмийн халамжийн сан нь 2623 хүнд халамжийн тэтгэвэр, 3198 хүнд асаргааны мөнгөн тэтгэмж, 10424 хүнд ахмад настаны хөнгөлөлт тусламж, 6780 хүнд жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн мөнгөн тэтгэмжийг зарцуулсан байна.



УЛААН ЗАГАЛМАЙН ЧИГЛЭЛЭЭР

Дүүргийн “Улаан загалмайн хороо” 2016 оны 9-р сард нийт 34 хүнд 785.4 мянган төгрөгний халамж үйлчилгээ үзүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 152 хүнээр буурч, 1614.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан хүн зардалаар

Үзүүлэлт	2015 он 09-р сар			2016 он 08-р сар		
	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/
Халамж үйлчилгээ	54	178	2400000	6	34	785400
Анхны тусламжийн сургалт	7	64	-	10	369	
Гамшгийн тусламж	1	8	400000			
Донорын өдөрлөг	2	61		4	301	
Дүн	64	311	2800000	20	704	785400

Мөн анхны тусламжийн 10 удаагийн сургалт зохион байгуулж, сургалтанд нийт 369 иргэн, донорын өдөрлөг арга хэмжээг 4 удаа зохион байгуулж 301 иргэнийг хамруулсан байна.



АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО

2016 оны 9 дугаар сард татварын хэлтсийн мэдээлэл боловсруулалтын санд бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо 15550 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.8 хувиар буюу 715 аж ахуй нэгж байгууллагаар нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн аж ахуй нэгж байгууллагын 77.3 хувь буюу 12013 байгууллага нь ХХК байна. Оны эхнээс нийт 865 байгууллага шинээр бүртгэгдэж, 603 байгууллага хасагдсан байна.

Хүснэгт 11. Аж ахуй нэгж байгууллагын тоо

ААНБ-ын төрөл	ААНБ-ын хариуцлагын хэлбэр	2015.09	2016.09
ААН	ХК	10	13
	ХХК	11571	12013
	ББН	120	127
	ЗБН	88	94
	ХХН	34	45
	Хоршоо	53	48
	Хадгаламж зээлийн хоршоо	67	59
	Төрийн өмчит үйлдвэрийн газар	28	33
	ОНӨҮГ	7	12
	Салбар	733	725
	Төлөөлөгчийн газар	8	21
	Төлөөний газар	1	3
	Боловсролын сургалтын байгууллага	1	1
	Нийт	12721	13194
Төсөв болон ТББ	Төсөвт байгууллага	263	288
	Төрийн бус байгууллага	1520	1712
	Шашны байгууллага	40	42
	Сан	94	108
	Олон нийтийн байгууллага	197	206
Нийт	2114	2356	
Бүгд		14835	15550



АЖ ҮЙЛДВЭР


Аж үйдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2016 оны 9 сард 1420.6 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12.5 хувь буюу 158.7 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь хувцас үйлдвэрлэл 25.2 хувиар буурч, хүнс үйлдвэрлэл 37.0 хувь, хэвлэлийн үйлдвэрлэл 13.6 хувь, бусад үйлдвэрлэл 42.0 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 12. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн /сая.төг/

Салбар		2015.09	2016.09	Өсөлт, бууралт/%/	Зөрүү
Бүгд		1261.9	1420.6	12.5	158.7
Үүнээс:	Хувцас үйлдвэрлэл	805.5	601.8	-25.2	-203.7
	Хүнс үйлдвэрлэл	122.3	167.6	37.0	45.3
	Хэвлэлийн үйлдвэрлэл	186.7	441.8	136.6	255.1
	Бусад үйлдвэрлэл	147.3	209.3	42.0	62.0

2016 оны 9 дугаар сарын байдлаар нийт үйлдвэрлэлийн 42.4 хувийг хувцас үйлдвэрлэл, 11.8 хувийг хүнс үйлдвэрлэл, 31.1 хувийг хэвлэлийн үйлдвэрлэл, 14.7 хувийг боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Зураг 10. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн



ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

ИРГЭНИЙ БҮРТГЭЛ

Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэс нь 2016 оны 9-р сарын байдлаар иргэний бүртгэлийн 8 төрлийн үйлчилгээг 1354 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 9.3 хувиар, буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 13. Иргэний бүртгэлийн мэдээ

Үзүүлэлт		2015.09	2016.09
Нийт		31471	29865
Шинэ төрсөн		3045	3065
Гэрлэлт		678	728
Гэр бүл цуцлалт		226	264
Хүүхэд үрчлэлт		53	40
Эцэг тогтоосон		1554	1486
Овог, нэр өөрчлөх		171	189
Иргэний үнэмлэх олголт	16 нас хүрч шинээр авсан	1565	1665
	дахин олголт	4006	4930
Шилжилт хөдөлгөөн	шилжин ирсэн	8781	8193
	шилжин явсан	11392	9305

ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ

Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэс нь 2016 оны 9-р сарын байдлаар 1671 иргэн, аж ахуй нэгж байгууллагад эд хөрөнгийн бүртгэлийн 5 төрлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Хүснэгт 14. Эд хөрөнгийн бүртгэлийн мэдээ

Үзүүлэлт	Үйлчлүүлсэн тоо			Үйлчилгээний хөлс /мян.төг/		
	Нийт	Газар	Газраас бусад	Нийт	Газар	Газраас бусад
Нийт	1706	689	1017	94781390	4486010	90295380
Анхны бүртгэл	57	21	36	30000	20000	10000
Өмчлөх эрх шилжих гэрээ	277	108	169	6324000	2436000	3888000
Барьцааны гэрээ	1138	484	654	86278.4	1333.0	84945.4
Бусад гэрээ	2		2	20000	0	20000
Бүртгэлд өөрчлөлт оруулах	35	11	24		172000	324000
Лавлагаа, хуулбар	197	65	132	1633000	525000	1108000

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2016 оны 9 сарын байдлаар Дүүргийн Засаг даргын 17 удаагийн захирамжаар 415 иргэний газрын эрхийг баталгаажуулж, газар эзэмших эрхийн нэр шилжүүлэх, талбайг өөрчлөх, хугацаа сунгах зэрэг газрын асуудлыг шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд зуслангийн газар өмчлүүлж эхэлсэнтэй холбогдуулан иргэдээс /www.land.ulaanbaatar.mn/ цахим сайтад бүртгүүлсэн 1516 иргэний бүртгэлийг шүүж тухай бүрт хариу өгч ажиллаж байна.

Хүснэгт 15. Үзүүлсэн үйлчилгээ

№	Нэр	Тоо
1	Мэдээллийн санд нэр сольсон	272
2	Нэр сольсон	18
3	Хаяг сольсон	0
4	Хаяг оруулсан	40
5	Байшин оруулсан	123
6	Талбай хассан	26
7	Талбай нэмсэн	11
8	Өмчилсөн газар хуваасан	25
9	Зураг нийлүүлсэн	1
10	Томоор орсон зураг хуваасан	17
11	Зураг өөрчилсөн	42
12	Шинээр оруулсан	227
13	Эзэмшлийн хэлбэр өөрчилсөн	3
14	Захирамж тэмдэглэсэн	13
15	Бүртгэл оруулсан	2
16	Барьцаа бүртгэсэн	51
17	Барьцаа чөлөөлсөн	21
18	Регистр зассан	5
19	Өмчлөлийг тэмдэглэсэн	61

20	Байршил өөрчилсөн	10
21	Бусад	9
21	Архивын хавтас үүсгэсэн	20
	НИИТ	997

2016 он гарсаар газрын төлбөрийн 171.0 сая төгрөг, газрын гэрчилгээний төлбөр 8.5 сая төгрөг, бусад бүртгэлээс 1.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны 9 дугаар сарын байдлаар 6121.0 мян.м² зам талбай цэвэрлэж, 83.6 мян.м³ хог тээвэрлэсэн байна. Өнгөрсөн оноос цэвэрлэсэн талбай 104.2 мян/м² буюу 14.1 хувиар буурч, тээвэрлэсэн хог 5.4 мян/м³ буюу 6.9 хувиар өссөн байна. Ажил үйлчилгээний орлого 4784.3 сая төгрөг болж өнгөрсөн оноос 1125.3 сая төгрөг буюу 30.7 хувиар өссөн байна. Орлогын эх үүсвэрийг ангилвал 18.2 хувийг зам талбай, 36.8 хувийг гэр хорооллоос, 20.4 хувийг орон сууцнаас, 24.5 хувийг албан газраас тус тус олсон орлого эзэлж байна.

Хүснэгт 16. Тохижилтын ажил

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2015.09	2016.09	Зөрүү	%
Цэвэрлэсэн талбай		мян.м ²	7125.2	6121.0	-1004.2	14.1
Тээвэрлэсэн хог		мян.м ³	78.2	83.6	5.4	6.9
Үүнээс:	Орон сууц	мян.м ³	19.6	20.9	1.3	6.6
	Гэр хороолол	мян.м ³	35.2	37.6	2.4	6.8
	Албан газар	мян.м ³	11.7	12.5	0.8	0.7
	Зам талбай	мян.м ³	11.7	12.5	0.8	0.7
Ажил үйлчилгээний орлого		сая.төг	3659.0	4784.3	1125.3	30.7
Үүнээс:	Зам талбай	сая.төг	659.7	873.0	213.3	32.3
	Гэр хороолол	сая.төг	1388.2	1760.1	371.9	26.8
	Орон сууц	сая.төг	813.3	977.8	164.5	20.2
	Албан газар	сая.төг	797.7	1173.4	375.7	47.1

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2016 оны 09 сарын байдлаар дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 144 өргөдөл, гомдол ирснээс 124-г хуулинд заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэх хугацаа болоогүй, шийдвэрлэх шатандаа явж байгаа 20 өргөдөл, гомдол хянагдаж байна.

Хүснэгт 17. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Ангилал	НИЙТ	Шийдвэрлэх шатандаа байгаа			Шийдвэрлэж хариу өгсөн		
		Хугацаан-даа байгаа	Хугацаа хэтэрсэн	Бүгд	Хугацаан-даа байгаа	Хугацаа хэтэрсэн	Бүгд
1800-1200 тусгай дугаарын утас	10	4	0	4	6	0	6
www.ub1200.mn цахим хуудас	1	1	0	1	0	0	0
Засгийн газрын 11-11 төв	10	1	0	1	9	0	9
Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв	71	10	0	10	61	0	61
Нутгийн захиргааны байгууллагууд	52	4	0	4	48	0	48
Smart UB аппликейшн, Clean UB аппликейшн	0	0	0	0	0	0	0
Мессеж	0	0	0	0	0	0	0
Шуурхай удирдлага, зохицуулалтын төв	0	0	0	0	0	0	0
НИЙТ	144	20	0	20	124	0	124



ОСОЛ, ГЭМТ ХЭРЭГ

2016 оны 9сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт 1857 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар буюу 101 тохиолдлоор өссөн.

Хүснэгт 18. Гэмт хэрэг

Төрөл	Цагдаагийн I хэлтэст бүртгэгдсэн				Цагдаагийн II хэлтэст бүртгэгдсэн				
	2015.09	2016.09	Илрүүлэлтийн хувь	Хувь/%/	2015.09	2016.09	Илрүүлэлтийн хувь	Хувь/%/	
Хэргийн ангилал	Хөнгөн	482	567	63.0	17.6	300	289	78.8	-3.7
	Хүндэвтэр	507	414	54.9	-18.3	318	462	42.4	45.3
	Хүнд	74	56	82.4	-24.3	37	33	81.8	-10.8
	Онц хүнд	29	17	60.0	-41.4	9	19	88.9	111.1
Гэмт хэргийн төрөл	Хүн амь	1				7	11	100	57.1
	Учрал	6	2		-66.7	3	4		33.3
	Залилан	192	200	70.3	4.2	35	27	76.9	-22.8
	Хүчин	3	4	75.0	33.3	7	11	100	57.1
	Танхай	76	50	64.7	-34.2	44	36	78.3	-18.2
	Булаалт	7	10	50.0	42.8	4	7	57.1	75
	Хулгай	302	360	47.0	19.2	245	372	40.3	51.8
	ББМГУ	164	209	87.5	27.4	203	209	90	2.9
	Дээрэм	17	24	63.6	41.1	12	19	66.7	58.3
	ТХХАББАЖЗ	68	58	95.4	-14.7	55	36	83.3	-34.5
	Бусад	256	137	63.0	-46.5	49	71		44.9
	Бүгд	1092	1054	60.7	-3.5	664	803	53.2	20.9

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧИЛ

Тус тасгийн алба хаагчдын гудамж замд хийсэн хяналт шалгалтаар 2016 оны 9 сард нийт 4790 зөрчил илрүүлсэнээс Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 27.1 дэх хэсгийн заалт зөрчин согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 139 мөн хуулийн 31.2.3, 32.2, 43.2, 52.1 дэх хэсгүүдэд заасан зөрчилтэй 13 тээврийн хэрэгслийг түр саатуулан журамлан Жолоочийн даатгалын тухай хуулийн 28.1.1 дэх хэсэгт заасан зөрчилтэй 0, улсын дугаарын хязгаарлалт 1245, бүрэн бус 287, хамгаалах бүс хэрэглээгүй 1410, нийт 4491 жолоочийг 140.841.100 төгрөгөөр торгож ажиллав. Замын Цагдаагийн газар болон бусад албадаас зарлагдсан 7 дугаарыг илрүүлэн ерөнхий жижүүрт хүлээлгэн өгсөн. Цагдаагийн шалгах төхөөрөмж ашиглан 2013 оны А/130 дугаар тушаалаар баталсан “Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлж ASAP санд бүртгэлтэй сэжигтэн яллагдагч тээврийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнд оролцож байсан 0, Цагдаагийн нийтлэг үүргээр 2 зөрчил тус тус илрүүлсэн. Зам тээврийн ослын нийт 697 дуудлага мэдээлэл хүлээн авч шийдвэрлэсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 70 хувиар өссөн байна. Нийт бүртгэгдсэн гомдол мэдээллээс 8 буюу 1.1 хувь нь эд материалын хохиролтой зам тээврийн осол байна. Зам тээврийн ослын улмаас 5.075.000 төгрөгийн материаллаг хохирол учирсаны 5.075.000 төгрөгийн хохирлыг хэрэг бүртгэлтийн шатанд нөхөн төлүүлсэн нь нөхөн төлүүлэлт 100 хувьтай байна.

ХҮҮХЭД, ГЭР БҮЛ ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ

Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв нь 2016 оны 9-р сард нийт 149 хүнд хүрч ажилласан байна.

Хүснэгт 19. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалалын чиглэлээр хийсэн ажил

№	Үйл ажиллагааны чиглэл	Зохион байгуулагдсан ажил	Хамрагдсан хүний тоо
1	Хүүхдийн тусламжийн 108 утас	Ирсэн дуудлагын тоо	29
2	Ажилласан кейс	Асран хамгаалагч тогтоолгох - 1	12
		Бэлгийн хүчирхийлэл – 1	
		Бие махбодийн хүчирхийлэл - 6	
		Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн - 0	
		Хүүхдийг үл хайхрах хүчирхийлэлд өртүүлсэн - 1	

		Хаагдсан кейсийн тоо - 2	
		Хүүхдийн эрхийн зөрчлийн 1 кейс дээр ажилласан.	
3	Хүүхэд хамгааллын чиглэлээр	Хүчирхийлэл үйлдэгч 5 иргэнд захиргааны хариуцлага хүлээлгэж, 1 хүүхдийг 24 цагийн цэцэрлэгт хамруулж, зам тээврийн ослын 1 дуудлага хаагдсан байсанг сэргээлгэн хэрэг нь прокурорт шилжсэн. Хаагдсан дуудлага 12	19
4	Хүүхэд хөгжлийн чиглэлээр	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд бага насны хүүхэдтэй ажиллах зөв мэдлэг, ур чадвар, эвдүй, эерэг хандлага, стандартын шаардлагад нийцсэн мэдлэг чадвартай хүүхэд харагчийг бэлтгэх зорилгоор Хүүхэд харагч бэлтгэх 3-р ээлжийн сургалтын зохион байгуулсан. Энэхүү сургалтанд нийт 30 хүүхэд харагч 5 өдрийн 40 цагийн хичээлд сууж хүүхэд харах эрхээ авсан.	30
5	Гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр	Хүүхэд харах үйлчилгээ эрхэлж буй 11 иргэний 5 объектод хариуцсан мэргэжилтнүүд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар хэд хэдэн зөрчил илэрсэн. Зөрчлийг нэн даруй арилгуулахаар санамж бичиг хүргүүлэн, дахин шалгалтыг хийсэн.	40
6	Гэр бүлийн хамгааллын чиглэлээр	ДЗМОУБ, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвүүдтэй хамтран Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг жирийн ерөнхий боловсролын сургуульд тэгш хамрагдах боломжийг олгох зорилготой хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй” тусгай төслийг танилцуулж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах нь” сэдэвт сургалтыг хороодын нийгмийн ажилтануудын дунд зохион байгуулж, 17, 37, 72 дугаар сургууль дээр хэрэгжүүлэх болсон.	19 нийгмийн ажилтан

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ

Тус хэлтэс нь 2016 оны 9 сарын байдлаар нийт 1429 нэгжид шалгалт, 856 нэгжид хяналт хийж гүйцэтгэсний 65.3 хувь нь ААНБ-г, 34.6 хувь нь иргэнийг хамарсан байна.


Хүснэгт 20. Хяналт, шалгалт, зөрчил, торгууль шийтгэвэрийн мэдээ, тасгаар

Үзүүлэлт		Нийтдүн	ХХААҮҮБОХ- ынтасаг	ЭМБХ- ынтасаг	ХНХХ- ынтасаг
Хяналт	ААНБ	510	115	376	19
	Иргэн	346	203	143	0
	Дүн	856	318	519	19
Шалгалт	ААНБ	983	549	408	26
	Иргэн	446	397	46	3
	Дүн	1429	946	454	29
Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил	Нийт илэрсэн	1412	620	777	15
	Арилгасан	866	385	471	10
Торгууль, шийтгэвэр	Тоо	185	102	79	4
	Үнийн дүн мян.төг	30200	13326	16188	686
Зөвлөн туслах	ААНБ	361	222	103	11


сургалт, сурталчилгаа	Иргэн	445	95	350	0
	Дүн	836	317	453	11

Энэ хугацаанд нийт 1412 зөрчил илэрсний 866 буюу 61.3 хувийн зөрчлийг арилгасан ба нийт 185 торгууль, шийтгэвэрт нийт 30.2 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Зураг 13. Хийсэн хяналт тоо, тасгаар



Зураг 14. Хийсэн шалгалтын тоо, тасгаар



АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, ГАМШИГ

Хэлтсийн Аврах, гал унтраах 10 дугаар анги нь 2016 оны 9 дугаар сарын байдлаар 267 удаагийн 6744 цагийн харуул ээлжийн үүрэг гүйцэтгэх явцад гамшиг ослын дуудлагаар 645 удаа гарснаас удаагийн гамшгийн голомтод 399 удаа ажиллаж гал түймэр дээр нийт 177.7 цаг ажиллаж 477.5 тонн ус, 900 л хөөс шатах тослох материал дизель түлш 20.9 мянган литр буюу 35.0 сая төгрөгийг зарцуулан аж ахуй нэгж байгууллага, иргэдийн 4.4 тэрбум төгрөгний өмч хөрөнгийг авран хамгаалж, 188 гал түймрийг иргэд унтрааж, 10 гал түймэрээрөө унтарч, худал дуудлагаар 17 удаа тус тус гарч ажиллан 250 байшин, барилга, 179 хүний амь насыг авран хамгаалсан байна.

ЦЭРГИЙН ШТАБ

Дүүргийн өрхийн эмнэлэгийн эмч нарын цэргийн бэлтгэлийн сургалтыг 2016 оны 9 дүгээр сарын 15-наас 16-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 027 дугаар ангийн дайчилгаатай тусгай тактикийн хээрийн сургуулийг түшиглэн зохион байгуулсан. Цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын шилжилт, хөдөлгөөнийг Нийслэлийн ЗДТГ-ын даргын 2009 оны 101 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу явуулж, тоо бүртгэлийн мэдээлийн санд баяжилт хийж, мөн цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн иргэдийг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2016 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Зэвсэгт хүчний 027 дугаар ангитай хамтын ажиллагааны хүрээнд тус ангид ажилладаг 5 офицер, ахлагч, ажилтан албан хаагчдад дүүргээс буцалтгүй тусламж болгон 3 хүн тус бүр 500.000 төгрөг, 5 ханатай гэр 1 хүнд тус тус олгов.

Дүүргийн Засаг даргын захирамж гарган Цэргийн дүйцүүлэх албан хаагчдын мэдлэг дадлага олгох гүнзгийрүүлэх шатны сургалтыг Хилийн цэргийн 0164, ОБЕГ-ын харьяа аврах тусгай ангийн материаллаг баазыг түшиглэн 09 дүгээр сарын 21-нээс 10 дугаар сарын 03-ны өдрүүдэд 14 хоногийн хугацаатай зохион байгуулан явуулсан.

АХМАДЫН ХОРОО

Чингэлтэй дүүргийн Ахмадын хорооноос ахмадын зөвлөлийн дарга нарын ээлжит семинарыг хийж цаг үеийн ажлаар үүрэг даалгавар өгч ажилласан. Мөн Ахмадын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх талаар ээлжит бус өргөтгөсөн семинарыг 2 удаа хороодын Засаг дарга, ажлын албаны дарга, ахмадын зөвлөлийн дарга нарт үүрэг чиглэл өгч баярыг хамтран зохион байгууллаа.

Монголын гэр бүлийг алдаршуулах төвтэй хамтран гэр бүл, аав, ээжийгээ алдаршуулан хөдөлмөр бүтээлийг сурталчилах талаар зөвлөгөө, удирдамж чиглэлийг Ахмадын зөвлөлийн дарга нарт танилцуулж, гарын авлага материалыг тарааж өгсөн.

Дүүргийн Халамжийн хэлтэстэй хамтран амьдралын боломж тааруу 182 ахмад настнуудыг хороодын Засаг даргын тодорхойлолтыг үндэслэн 6 хоногийн амралтанд үнэгүй амрууллаа.

Хороодын ахмадын зөвлөлүүд санаачлан дотоод, гадаадын аялал, амралт зугаалганд ахмадуудыг өргөнөөр оролцуулах уриалга гарган ОХУ-ын Буриадын Итгэлт хамба-Байгал нуур-Улан үд, Хөвсгөл далай, Хамрын хийд, Амарбаясгалант, Эрдэнэзуу,

Төвхөн, Аглаг бүтээлийн хийдүүд, байгалийн үзэсгэлэнт газруудын аялалд 280 гаруй ахмад настан хамрагдаад байна.

БНХАУ-аас уригдан ирсэн Ахмад уран сайханчдын тоглолтыг Амгалан дахь “Жанжин” клубт дүүргийн 400 гаруй ахмадуудыг урилгаар үзүүлээ.

Дүүргийн Засаг даргатай байгуулсан 2016 оны үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх ажлын хүрээнд ахмадуудын дунд “100 буудалт даам”-ны дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг батлагдсан удирдамжийн дагуу 2016.09.17-ны өдөр 49 дүгээр сургууль дээр зохион байгуулж явууллаа.

Мөн Иргэдийн спортын 5 дугаар наадмын хүрээнд ахмадуудын хийн дасгал аэробекийн тэмцээнийг 2016.09.17-ны өдөр спорт хороотой хамтран зохион байгуулж явууллаа.

3 дугаар хорооны Засаг даргын ажлын алба, Ахмадын зөвлөлөөс ахмадуудын дунд “Нийтийн бүжиг”-ийн тэмцээнийг зохион явууллаа.

Чингэлтэй дүүргийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Энх ундрага” ХХК, Талимаа ХХК, “Зөв сэтгэж, Зөв амьдарцгаая ТББ, Ай-Эм-Тек ХХК-уудтай хамтран зөв хоололт, эрүүл насжилт-настны эрүүл мэнд, эмийн зөв хэрэглээ, нуруу нугас, өвдөгний үений өвчнөөс урьдчилан сэргийлэх, анхаарх чиглэлээр эрүүл мэндийн 4 удаагийн сургалтанд 120 гаруй ахмадуудыг хамруулсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 2016 оны Олон улсын Ахмадын өдрийг “Насаар ялгаварлан гадуурхахын эсрэг зогсцгооё” уриан дор ЗДТГ, Ахмадын хорооноос бүх хороодын Засаг дарга, ажлын албаны дарга, Ахмадын зөвлөлийн дарга нарт заавар зөвлөмж, семинар өгч хамтран ажилласан.

Олон улсын болон Монголын ахмадын баяраар давхардсан тоогоор нийт 15256 ахмадад Засаг даргын Тамгын газар, Ахмадын хороо, дэвсгэрийн зарим аж ахуйн нэгж байгууллага, ТББ-тай хамтран нийт 67480.0 сая төгрөгийн үнэ бүхий хүндэтгэл үзүүлсэн. Үүнд:

- Дүүргийн төсвөөс: 14054 ахмадад 44000.0
- Дүүргийн Халамж үйлчилгээний хэлтэс 1000 ахмадад 15000.0
- Төрийн бус байгууллага, дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагууд: 202 ахмадад 8480.0 мянган төгрөг

Тунамал авъяас” урлагийн наадамд 13 хорооноос 56 ахмад оролцсон.

Дүүргийн ИТХ-ын тогтоолын дагуу жил бүр Ахмад настанд “Ээлтэй байгууллага, иргэн”-ийг тусгай журмын дагуу шалгаруулдаг ба 2016 онд хороодоос Ахмад настанд ээлтэй байгууллагаар 10, Ээлтэй иргэнээр 9 хүнийг тодорхойлж ирүүлснийг ИТХ, ЗДТГ, Ахмадын хорооны хамтарсан комисс газар дээр нь явж шалган Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн шалгаруулав.

Мөн Ахмадын баярыг тохиолдуулан улс эх орон нийслэл, дүүргийнхээ хөгжил цэцэглэлтийн төлөө, идэвхи зүтгэл гарган ахмадын байгууллагын ажилд дэмжлэг туслалцаа үзүүлж байгаа ахмад настнуудыг шагнаж урамшуулахаар ИТХ, ЗДТГ-т 32 ахмадын шагналын материалыг хүргүүлж, шийдвэрлүүллээ. Эдгээр 56 ахмадуудаас дүүргийн ИТХ-ын “Чандмань одон”, “Хүндэт Өргөмжлөл”, Засаг даргын “Хүндэт Өргөмжлөл”, дүүргийн “Хүндэт тэмдэг” мөнгөн шагналаар, төрийн одон медал, салбарын Тэргүүний ажилтан тэмдэгээр шагнагдсан.

Шагналыг дүүргийн Ёслол хүндэтгэлийн өргөөнд 2016.09.30-ны өдөр дүүргийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Тамгын газрын дарга , Ахмадын хорооны дарга, удирдлагууд гардуулан өгч хүндэтгэл үзүүллээ.

Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор рашаан сувилал, амралт, аялалд 162, урлаг, спортын арга хэмжээнд 568, эрүүл мэндийн сургалт үйлчилгээнд 860 ахмад настанг хамруулав. 37 ахмадын хөдөлмөр алдрыг тэмдэглэн, ажил үйлс, бүтээлийг сурталчлан алдаршуулж , хэвлэл мэдээллийн хэрэгслээр 12 удаа ярилцлага, уулзалт, мэдээллийг явуулсан.



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ:

WWW.1212.MN

WWW.UBSTAT.MN

WWW.CHINGELTEI.GOV.MN



Хянасан: Хэлтсийн дарга Д.МӨНХЗУЛ

*Танилцуулга нэгтгэсэн:
мэргэжилтэн Б. Дэлгэр*

И-мэйл хаяг: chingeltei@nso.mn
Хаяг: Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг,
Нийслэлийн төр захиргааны
III байр 401 тоот
Утас: 70113013
70130767
11-310767